ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр Дугаар А/79 Шивээговь сум

Төв талбайн усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэх
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.л, 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төв талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн байгууллагын хуваарьт газрын усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх ажлыг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, айд өрхүүд зохион байгуулсугай.

2. Төв талбайн усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх албан байгууллага, аж ахуйн нэгжийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, зам дагуух ногоон зурвасын усалгаа арчилгаа хийх албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуваарийн дагуу өөрийн байгууллагынхаа хуваарьт газруудад усалгаа арчилгаа, зүлэгжүүлэлт хийх, ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулах, цаашид 7 хоног бүр усалгаа арчилгааг чанартай хийж гүйцэтгэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төв талбай болон цэцэрлэгт хүрээлэнд мод бут тарих, усалгаа арчилгаа, зүлэгжүүлэх ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг /1, 2 дугаар багийн Засаг дарга нар/-т, хяналт тавьж ажиллахыг /Байгаль хамгаалагч/ нарт даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/73 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ

42121Г451

Сумын Засаг даргын ...2021 оны ...05-р
сарын ...19 ний өдрийн ...А/79... дугаар
захирамжийн ...1...-р хавсралт

Төв талбайн усалгаа, арчилгаа, зүлэгжүүлэлт, цэцэгжүүлэлт хийх талбайн хуваарилалт



Сумын Засаг даргын 2021 оны 05-р
сарын 19 ний өдрийн А/79 дугаар
захирамжийн 2-р хавсралт

Ногоон байгууламжийн, усалгаа, арчилгаа, цэвэрлэгээний ажлыг хийх, хуваарийн зураглал

